

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2025//НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Алтанцэцэг Утас: 8000-7121 Цахим хаяг: tolinetugen@gmail.com Толин этүгэн аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Б.Отгон-Өлзий Утас: 99844655 Цахим хаяг: otgon1118@yahoo.com
Өмнөговь аймаг 2025 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Төлбөрийн акт	13
5.3 Зөвлөмж.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25 № 62

танай _____ -ны № _____ -т

ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТАМГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Д.УРАНЧИМЭГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өмнөговь аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар автомашин нийлүүлэгдэж ашиглалтын гэрээ байгуулан албан хэрэгцээндээ ашиглаж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хууль зүй дотоод хэргийн яамнаас 1,231,983.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 1,055,549.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 17,103.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 41,430.5 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардал 36,110.0 мянган төгрөг, томилолтын зардалд 9,060.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 17,314.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 22,744.8 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

дэмжлэгт 13,065.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 14,986.0 мянган төгрөг, тэтгэмж урамшууллын зардалд 4,620.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ, үндсэн 4 хяналтын хүрээнд 32 арга хэмжээ, удирдлага, зохион байгуулалт дотоод ажлын 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 97.6 хувьтай дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ЭСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)			
КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,174,000.00	11,663,318.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,174,000.00	11,663,318.00
354	Хангамжийн материал	3,174,000.00	11,663,318.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,904,588.00
35470	Бусад хангамжийн материал	3,174,000.00	9,758,730.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	693,385,134.23	692,669,275.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	693,385,134.23	692,669,275.98
392	Биет хөрөнгө	692,560,134.23	692,174,275.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	599,890,506.00	599,890,506.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-73,852,524.77	-92,874,979.97
39203	Авто-тээврийн хэрэгсэл	22,000,000.00	22,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,500,000.06	-22,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	168,600,895.36	176,976,320.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-66,963,979.60	-89,534,177.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,025,603.76	139,703,968.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,640,366.46	-41,987,362.12
393	Биет бус хөрөнгө	825,000.00	495,000.00
39301	Програм хангамж	1,320,000.00	1,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-495,000.00	-825,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	696,559,134.23	704,332,593.98
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	696,559,134.23	704,332,593.98
51	Засгийн газрын хувь оролцоо	696,559,134.23	704,332,593.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	263,301,770.00	263,301,770.00
51101	Өмч: - төрийн	263,301,770.00	263,301,770.00
512	Хуримтлагдсан үр дүн	183,935,425.75	191,708,885.50
51210	Өмнөх үеийн үр дүн	183,935,425.75	183,935,425.75
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	7,773,459.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	249,321,938.48	249,321,938.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	696,559,134.23	704,332,593.98

2.2 Аудит хийсэн санх

үүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)			
КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	978,136,268.00	1,522,125,190.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,201,030.00	71,795,781.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,201,030.00	71,795,781.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	12,201,030.00	61,605,685.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	00.00	10,190,096.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	965,935,238.00	1,450,329,409.28
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	834,764,400.00	1,345,355,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	834,764,400.00	1,345,355,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,170,838.00	104,974,209.28
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	131,170,838.00	104,974,209.28
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,017,177,133.43	1,505,540,988.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,017,177,133.43	1,505,540,988.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	797,822,455.02	1,347,931,093.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	574,930,123.52	1,010,758,303.91
210101	Үндсэн цалин	310,304,968.06	516,143,389.16
210102	Нэмэгдэл	180,612,979.43	324,576,644.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,160,110.69	53,453,364.50
210104	Урамшуулал	58,852,065.34	116,584,905.96

Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,874,096.19	126,043,795.48
210201	Тэтгэврийн даатгал	48,426,414.65	88,000,231.64
210202	Тэтгэмжийн даатгал	5,680,725.14	10,352,968.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,256,711.75	5,074,184.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,268,084.44	4,523,282.23
210205	Эрүүл мэндийн даатгал	10,242,160.21	18,093,129.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,255,541.18	17,103,366.72
210301	Гэрэл, цахилгаан	3,395,742.00	3,898,644.65
210302	Түлш, халаалт	7,670,439.18	10,644,272.07
210303	Цэвэр, бохир ус	3,189,360.00	2,560,450.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,092,615.70	39,870,549.65
210401	Бичиг хэрэг	9,989,200.00	12,199,900.00
210402	Тээвэр, шатахуун	11,731,000.00	15,789,023.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,072,415.70	4,626,626.65
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,100,000.00	6,300,000.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	155,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,189,000.00	29,810,000.00
210604	Урсгал засвар	10,189,000.00	29,810,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,958,800.00	9,060,000.00
210702	Дотоод албан томилолт	5,958,800.00	9,060,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,360,283.00	19,814,784.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,108,430.00	19,498,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,653.00	175,653.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	58,200.00	97,131.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,161,995.43	95,470,293.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,249,500.00	25,746,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,102,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,912,495.43	68,621,543.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	219,354,678.41	157,609,895.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,670,838.00	44,238,605.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,000,000.00	14,985,986.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	13,065,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,670,838.00	16,187,619.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	135,683,840.41	113,371,290.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	135,683,840.41	113,371,290.48
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/		0.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-39,040,865.43	16,584,201.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	8,810,742.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-8,810,742.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-39,040,865.43	7,773,459.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	965,935,238.00	1,450,329,409.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	965,935,238.00	1,450,329,409.28
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	834,764,400.00	1,345,355,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	834,764,400.00	1,345,355,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,170,838.00	104,974,209.28
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	131,170,838.00	104,974,209.28
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	946,264,638.00	1,444,029,409.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	946,264,638.00	1,444,029,409.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	726,909,959.59	1,286,419,513.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	574,930,123.52	1,010,758,303.91

Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан			
210101	Үндсэн цалин	310,304,968.06	516,143,389.16
210102	Нэмэгдэл	180,612,979.43	324,576,644.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,483,524.30	53,453,364.50
210104	Урамшуулал	58,528,651.73	116,584,905.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,874,096.19	126,043,795.48
210201	Тэтгэврийн даатгал	48,426,414.65	88,000,231.64
210202	Тэтгэмжийн даатгал	5,680,725.14	10,352,968.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,256,712.25	5,074,184.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,268,083.94	4,523,282.23
210205	Эрүүл мэндийн даатгал	10,242,160.21	18,093,129.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,255,541.18	17,103,366.72
210301	Гэрэл, цахилгаан	3,395,742.00	3,898,644.65
210302	Түлш, халаалт	7,670,439.18	10,644,272.07
210303	Цэвэр, бохир ус	3,189,360.00	2,560,450.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,592,615.70	41,430,513.65
210401	Бичиг хэрэг	9,989,200.00	12,199,900.00
210402	Тээвэр, шатахуун	10,231,000.00	17,503,987.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,072,415.70	4,626,626.65
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,100,000.00	6,300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,189,000.00	29,810,000.00
210604	Урсгал засвар	10,189,000.00	29,810,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,958,800.00	9,060,000.00
210702	Дотоод албан томилолт	5,958,800.00	9,060,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,860,283.00	19,814,784.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,608,430.00	19,498,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,653.00	175,653.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	58,200.00	97,131.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,249,500.00	32,398,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,249,500.00	31,296,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,102,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	219,354,678.41	157,609,895.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,670,838.00	44,238,605.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,000,000.00	14,985,986.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	13,065,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,670,838.00	16,187,619.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	135,683,840.41	113,371,290.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	135,683,840.41	113,371,290.48
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг/нэмэлт/		0.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	19,670,600.00	6,300,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,670,600.00	6,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,670,600.00	6,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,670,600.00	6,300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,670,600.00	6,300,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-19,670,600.00	-6,300,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН САН	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	ЗГ-Н ХУВЬ ОРОЛЦООНЫ ДҮН
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,301,770.00	249,321,938.48	183,935,425.75	696,559,134.23
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	263,301,770.00	249,321,938.48	183,935,425.75	696,559,134.23
Тайлант үеийн үр дүн	-	-	7,773,459.75	7,773,459.75

Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,301,770.00	249,321,938.48	191,708,885.50	704,332,593.98
---------------------------------------	----------------	----------------	----------------	----------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,345,355,200.00	1,231,983,909.52	(113,371,290.48)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,345,355,200.00	1,231,983,909.52	(113,371,290.48)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,312,684,200.00	1,199,312,923.52	(113,371,276.48)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,034,790,200.00	938,423,539.95	(96,366,660.05)
210101	Үндсэн цалин	538,409,100.00	516,143,389.16	(22,265,710.84)
210102	Нэмэгдэл	322,993,700.00	291,206,797.29	(31,786,902.71)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,758,400.00	53,453,364.50	(19,305,035.50)
210104	Урамшуулал	100,629,000.00	77,619,989.00	(23,009,011.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,348,900.00	117,125,969.20	(12,222,930.80)
210201	Тэтгэврийн даатгал	87,957,200.00	81,851,776.64	(6,105,423.36)
210202	Тэтгэмжийн даатгал	10,347,900.00	9,629,620.41	(718,279.59)
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,698,200.00	4,712,510.43	(985,689.57)
210204	Ажилгүйдлийн даатгал	4,649,800.00	4,186,412.30	(463,387.70)
210205	Эрүүл мэндийн даатгал	20,695,800.00	16,745,649.42	(3,950,150.58)
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,750,100.00	17,103,366.72	(4,646,733.28)
210301	Гэрэл, цахилгаан	5,696,900.00	3,898,644.65	(1,798,255.35)
210302	Түлш, халаалт	13,547,000.00	10,644,272.07	(2,902,727.93)
210303	Цэвэр, бохир ус	2,506,200.00	2,560,450.00	54,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,431,500.00	41,430,513.65	(986.35)
210401	Бичиг хэрэг	12,200,000.00	12,199,900.00	(100.00)
210402	Тээвэр, шатахуун	17,504,000.00	17,503,987.00	(13.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,627,500.00	4,626,626.65	(873.35)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	800,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,300,000.00	6,300,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,110,000.00	36,110,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,300,000.00	6,300,000.00	-
210604	Урсгал засвар	29,810,000.00	29,810,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	9,060,000.00	9,060,000.00	-
210702	Дотоод албан томилолт	9,060,000.00	9,060,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,435,500.00	17,314,784.00	(120,716.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,000,000.00	16,998,000.00	(2,000.00)
210804	Тээврийн хэрэгслийн татвар	270,900.00	175,653.00	(95,247.00)
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	44,000.00	(22,000.00)
210807	Газрын төлбөр	98,600.00	97,131.00	(1,469.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,758,000.00	22,744,750.0	(13,250.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,656,000.00	21,642,750.00	(13,250.00)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,102,000.00	1,102,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,671,000.00	32,670,986.00	(14.00)
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,671,000.00	32,670,986.00	(14.00)
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,986,000.00	14,985,986.00	(14.00)
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,065,000.00	13,065,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,620,000.00	4,620,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,345,355,200.00	1,231,983,909.52	(113,371,290.48)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,345,355,200.00	1,231,983,909.52	(113,371,290.48)
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,345,355,200.00	1,231,983,909.52	(113,371,290.48)

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	104,974,209.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	104,974,209.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	93,406,590.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	72,334,763.96
210102	Нэмэгдэл	33,369,847.00
210104	Урамшуулал	38,964,916.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,917,826.28
210201	Тэтгэврийн даатгал	6,148,455.00
210202	Тэтгэмжийн даатгал	723,347.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	361,673.83
210204	Ажилгүйдлийн даатгал	336,869.93
210205	Эрүүл мэндийн даатгал	1,347,479.87
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,654,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,654,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,567,619.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,567,619.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,567,619.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	104,974,209.24
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	104,974,209.24
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,974,209.24

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Прокурорын газар нь олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх, прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах, прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгох, хамт олны дунд эерэг хандлагыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг сайжруулахад чиглэн үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэрэг нь байгууллагын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 03-ний өдрийн 02 дугаар “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” тогтоол;
- Засгийн газрын 2024 оны 03 сарын 27-ний өдрийн 128 дугаар “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол;
- Сангийн сайдын 2024 оны 04 сарын 01-ний өдрийн А52 дугаар “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” тушаал;
- Ёс зүйн хорооны 2024 оны 02 сарын 19-ний өдрийн 05 дугаар “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам батлах тухай” тогтоол;
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 сарын 07-ний өдрийн 03 дугаар “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Прокурорын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Прокурорын газар нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,773.5 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	3,174,000.00	11,663,318.00	8,489,318.00
Үндсэн хөрөнгө	693,385,134.23	692,669,275.98	(715,858.25)
Нийт хөрөнгө	696,559,134.23	704,332,593.98	7,773,459.75
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	696,559,134.23	704,332,593.98	7,773,459.75
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	696,559,134.23	704,332,593.98	7,773,459.75

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд

байна. Үүнд :

- Бараа материалын үлдэгдэл 11,663.3 мянган төгрөг болж 8,489.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд бараа материал 88,698.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 80,209.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна. Бараа материалын үлдэгдлийн 9,758.7 мянган төгрөг нь бусад хангамжийн материалын үлдэгдэл, 1,940.6 мянган төгрөг нь шатах тослох материалын үлдэгдлийг нөөцөлсөн байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл нь 692,669.3 мянган төгрөг болж 715,858.3 мянган төгрөгөөр буурсан нь байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл нь 704,332.6 мянган төгрөг болж 7,773.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,345,355.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний зардлыг 1,231,983.9 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн байна. Төсвийн гүйцэтгэлийг 113,371.3 мянган төгрөгөөр хэмнэсэн нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг хэмнэж ажилласантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80101	Үндсэн үйл ажиллагаа	1,345,355.20	1,231,983.91	(113,371.29)	91.6
	Нийт	1,345,355.20	1,231,983.91	(113,371.29)	91.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 104,974.2 мянган төгрөгийн санхүүжилт орж, зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын захирамжаар орон нутгийн төсвөөс 104,974,209.24 мянган төгрөгийн санхүүжилт орсноос гүйцэтгэлээр “Нутгийн дэм” хөтөлбөрийн болон орон нутгийн нэмэгдэлд 92,820.2 мянган төгрөгийг, аймгийн ИТХ-ын даргын А/76 дугаар захирамжаар “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” -ний зардалд 2,500.0 мянган төгрөгийг, аймгийн Засаг даргын А/1994 дүгээр захирамжаар “Говийн бүсийн прокурорын байгууллагын нэгдсэн зөвлөгөөн,уулзалт,сургалт”-ын арга хэмжээнд 9,654.0 мянган төгрөгийг тус тус зориулалтын дагуу зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өмнөговь аймгийн Прокурорын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дансны өглөг, албан хэрэг хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Толин этүгэн аудит ХХК-ийн аудитын аудитор Б.Эрдэнэчимэг, ахлах аудитор Б.Алтанцэцэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер Д.Гэрэлхүү, хоёр дахь шатны хяналтыг гүйцэтгэх захирал Б.Отгон-Өлзий нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа, аудитын менежер Т.Хонгорзул, дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь аймгийн прокурорын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн Ц-1/103 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,017,180.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,257.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага үндсэн цалин, гэрэл цахилгаан, түлш халаалт, шуудан холбоо интернэтийн зардлыг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд тусгайлан аудит хийгдээгүй болно.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	110,000.0	1	110,000.0	100%
Нийт дүн	2	110,000.0	2	110,000.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалт болон хандив тусламжаар бий болсон үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлийг нягтдан бодох бүртгэлийн дагуу данс бүртгэлд тусгасан эсэхийг тулган баталгаажуулах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хяналтын байгууллагад шилжүүлсэн				
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
												-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								